



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/61

Чойбалсан

Г “Үндэсний сурын спортыг хөгжүүлэх” төсөл Г
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5, “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.2.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 18-1/01 тогтоолоор батлагдсан аймгийн 2024 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний 1.3 дахь заалт, “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 19/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний сурын спортыг хөгжүүлэх арга хэмжээнд зориулж 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлж, төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Дэмжлэгт шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 2.50 дахь “Үндэсний сурын спортыг хөгжүүлэх” төслийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Биеийн тамир, спортын газартай байгуулах орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулан батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т даалгасугай.

4. Арга хэмжээг чанартай зохион байгуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг олон нийтэд танилцуулж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газар (Б.Чимэддорж)-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ш.Ёл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

212401112

Аймгийн Засаг даргын 2024 оны
 01 дугаар сарын 28 ны өдрийн
 01 дугаар захирамжийн хавсралт



ҮНДЭСНИЙ СУРЫН СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ
 ТӨСЛИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА

Д/д	Спортын төрөл	Үйл ажиллагаа	Төсөв өртөг (төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн
1.	Үндэсний спортыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийтийн биеийн тамирын нэг төрөл болгож хөгжүүлэх оролцоог нэмэгдүүлэх	Эрэгтэй, эмэгтэй багийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх	2,000,000	Арга хэмжээний тоо	1
				Нийт оролцох тамирчдын тоо	20
		Зүүн бүсийн харвааны тэмцээн зохион байгуулах	5,000,000	Арга хэмжээний тоо	1
				Нийт оролцох тамирчдын тоо	60
		Холимог багийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх	2,500,000	Арга хэмжээний тоо	1
				Нийт оролцох тамирчдын тоо	20
2	Үндэсний сурын спортоор хичээллэхийн ач тус, үр дүнг олон нийтэд танилцуулах, сурталчлах зардал		500,000	Мэдээллийн тоо	3
НИЙТ ДҮН				10,000,000	